



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗАР**



ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР  
**СУРГАЛТ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ТӨВ**

# **ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЦАХИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**(Албан хэрэгцээнд)**

**УЛААНБААТАР ХОТ**

**2018**

### **Судалгааны багийн гишүүд:**

- А. Энхбаатар /Хууль эрх зүй хамтын ажиллагааны газрын дарга/  
О.Ганболд / Хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын судалгаа, шинжилгээ хариуцсан судлаач/  
С. Зулцэцэг /Гэр бүл, залуучуудын бодлогын судалгаа шинжилгээ хариуцсан судлаач/

**Мэдээлэл цуглуулсан:** /Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсүүд/

### **Тайлан боловсруулсан:**

- О.Ганболд / Хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын судалгаа, шинжилгээ хариуцсан судлаач/

### **Хянан тохиолдуулсан:**

- С.Болорцэцэг /Сургалт, судалгаа, мэдээллийн төвийн захирал/

---

### **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР СУРГАЛТ, СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ТӨВ**

Хаяг: Төрийн өмчийн XI байр  
Бага тойруу 44, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар  
Монгол Улс  
Утас: 262209, 262109, 62263097

## АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	4
Графикийн жагсаалт	5
Товчилсон үгийн жагсаалт	7
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ</b>	<b>8</b>
1.1 Судалгааны хэрэгцээ, шаардлага	8
1.2 Зорилго, зорилт	10
1.3 Судалгааны хамрах хүрээ	10
1.4 Судалгааны түүвэрлэлт	10
1.5 Мэдээлэл боловсруулалт	12
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ЦАХИМ ХЭРЭГЛЭЭ, ТҮҮНИЙГ ЗӨВ, ЗОХИСТОЙ АШИГЛАХ ТАЛААРХИ МЭДЛЭГ, ХАНДЛАГА</b>	<b>13</b>
2.1 Судалгаанд хамрагдсан хүүхдүүд болон эцэг эхчүүдийн ам зүйн зарим үзүүлэлт	13
2.2 Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал	15
2.3 Өсвөр үе болон эцэг эхчүүдийн цахим хэрэглээний талаархи мэдлэг, хандлага	18
2.4 Цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил	22
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЕБС-ИАС ӨСВӨР НАСНЫХАНД ЦАХИМ ОРЧНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР МЭДЛЭГ ОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b>	<b>27</b>
3.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж	27
3.2 Цахим хэрэглээний талаарх сургуулийн багш, нийгмийн ажилтнуудын мэдлэг, хандлага	28
3.3 ЕБС-д цахим орчны эрсдлийг таниулах, урьдчилан сэргийлэх талаар хичээл явуулах болон сургалтын материал байгаа эсэх	30
<b>ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b>	<b>33</b>
Хавсралт 1. Өдөр өнжүүлэх төвүүдээс авах асуулга	38
Хавсралт 2. Эцэг эхчүүдээс авах асуулга	40
Хавсралт 3. ЕБС-ын багш, нийгмийн ажилтнуудаас авах асуулга	41

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ

Хүснэгт 2. Асуулга судалгаанд хамрагдагсдын хүйсийн үзүүлэлт

Хүснэгт 3. Асуулга судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн насны үзүүлэлт

Хүснэгт 4. Асуулга судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн насны үзүүлэлт

Хүснэгт 5. Асуулга судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдийн ажилладаг салбар

Хүснэгт 6. Асуулга судалгаанд хамрагдсан багш, нийгмийн ажилтнуудын ерөнхий шинж, хувиар

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Өсвөр үеийнхний цахим хэрэглээ, хувиар

График 2. Өсвөр үеийнхний интернет хэрэглэж буй шалтгаан, хувиар

График 3. Интернетийн хэрэглээний эх үүсвэр, хувиар

График 4. Төхөөрөмжөөр интернетэд холбогдох байдал, хувиар

График 5. Интернет хэрэглээний хугацаа, хувиар

График 6. Түгээмэл ашигладаг аппликейшны төрлүүд, хувиар

График 7. Интернет ашиглахыг хэрхэн сурсан байдал, хувиар

График 8. Цахим орчинд өсвөр үеийнхний дотны туслагч, хувиар

График 9. Цахим орчинд хувийн нууц мэдээллээ хамгаалах тохиргооны мэдлэгийн түвшин, хувиар

График 10. Эцэг эхчүүдийн цахим орчны шүүлтүүрийн программ хангамжийн мэдлэг, хувиар

График 11. Фейсбүүкийн хэдэн хаяг ашигладаг вэ, хувиар

График 12. Цахим орчинд танихгүй хүнтэй чаталж байсан эсэх, хувиар

График 13. Найзуудаа цахим орчинд шоолж дүрс бичлэг оруулж байсан эсэх, хувиар

График 14. Найзын хүсэлт авахдаа хэнийг нэмдэг вэ, хувиар

График 15. Фейсбүүкээр зүй бус утгатай зурвас мэйл авч байсан эсэх, хувиар

График 16. Садар самууныг сурталчилсан мэдээлэлтэй тааралдаж байсан эсэх, хувиар

График 17. Эцэг эх, асран хамгаалагчаас интернетийн гэрээс байгуулахдаа насанд хүрээгүй хүн байгааг асуусан эсэх, хувиар

График 18. Цахим орчинд хүчирхийлэлд өртвөл хэнд хандах вэ, хувиар

График 19. Эцэг, эх интернет хэрэглээний цаг, агуулгад хяналт тавьдаг эсэх, хувиар

- График 20. Цахим орчинд гутаан доромжлуулах, ялгаварлан гадуурхагдвал хэнд хандах вэ, хувиар
- График 21. Сурагчдад зориулсан цахим хэрэглээний модуль хөтөлбөр байдаг эсэх, хувиар
- График 22. Өсвөр үеийнхний гар утасны дугаарын бүртгэл, хувиар
- График 23. Багш, нийгмийн ажилтнуудын байршил, хувиар
- График 24. Цахим орчинд хувийн нууцаа хамгаалах тохиргооны мэдлэгийн түвшин, хувиар
- График 25. Цахим орчны шүүлтүүрийн программ хангамж ашигладаг эсэх, хувиар
- График 26. Цахим орчны зохисгүй хэрэглээний талаар сурагчид зөвлөгөө авахаар хандаж байсан эсэх, хувиар
- График 27. Цахим орчинд сурагч хүчирхийлэлд өртвөл та өөрийгөө зөвлөгөө өгөх чадвартай эсэх, хувиар
- График 28. Зөвлөгөө өгөх чадваргүй гэж хариулсан багш нарын шалтгаан, хувиар
- График 29. ЕБС-д сургалтын модуль хөтөлбөр гарын авлага байдаг эсэх, хувиар
- График 30. ЕБС-ийн сурагчдад цахим орчны зохистой хэрэглээний талаарх мэдлэг олгох багш хэрэгцээтэй эсэх, хувиар

## **ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР**

<b>ГБХЗХГ</b>	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
<b>ЗГХАГ</b>	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>МҮОНРТ</b>	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
<b>НҮБ</b>	Нэгдсэн үндэстний байгууллага
<b>ССМТ</b>	Сургалт судалгаа мэдээллийн төв
<b>ХХЗХ</b>	Харилцаа холбооны зохицуулах хороо
<b>ХХМТГ</b>	Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар
<b>ЦЕГ</b>	Цагдаагийн ерөнхий газар

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

## 1.1 СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Интернет болон цахим технологийн эрин үед хүүхдийн сурах, хөгжих, тоглох, бие биетэйгээ харилцах хэлбэр үндсээрээ өөрчлөгдөж тэдэнд өөрийгөө илэрхийлэх, мэдлэг боловсрол эзэмших, авьяас чадвараа хөгжүүлэх маш өргөн боломжууд нээгдэж байна. Гэвч нөгөө талаас интернет болон цахим орчинд хүүхдүүд өөрсдийн насанд тохироогүй зохисгүй контент буюу мэдээлэл, зураг, бичлэг зэргийг олж үзэх, садар самуун, хүчирхийллийн шинж чанартай контентыг бусдаас хүлээж авах, хүчирхийлэл, бусад гэмт хэргийн хохирогч болох явдал нэмэгдэж байгааг харгалзан НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх 5 дугаар тайлангийн зөвлөмжид интернет болон нийгмийн сүлжээнд тавигдсан хүүхдийн сайн сайхан байдалд хор хохирол учруулах мэдээ материалаас тэднийг хамгаалахад чиглэсэн бүхий л арга хэмжээг авахыг Хүүхдийн эрхийн хороо онцгойлон анхааруулсан юм.

Манай улсад энэ асуудлыг Хүүхдийн эрхийн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад хууль, түүнийг даган гарсан журам дүрэм боловсруулж эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч цахим орчинд хүүхдийн хамгаалагдах эрх зөрчигдсөөр байгааг статистикийн тоо баримтууд харуулсаар байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол улсын интернет хэрэглэгчийн тоо 69 дахин нэмэгдэж 2008 онд 42.000 байсан уг тоо өнгөрсөн 2017 онд 2.910.778-д хүрснээр ази тивд нэгдүгээрт, дэлхийд аравдугаар байранд жагсаж байна<sup>1</sup>. Цагдаагийн байгууллагад цахим орчноор дамжуулан хүүхдийн эрхэд халдсан зөрчил 2012 онд 17 цахим гэмт хэрэг бүртгэгдсэн бол 2018 оны байдлаар 279 гэмт хэрэг бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэргийн гаралт 2 дахин ихэссэн байна<sup>2</sup>. Үүнийг 2012 онтой харьцуулбал энэ төрлийн гэмт хэргийн гаралт улсын хэмжээнд 20 дахин ихэссэн үзүүлэлттэй ба үүний дийлэнх нь фейсбүүкээр дамжуулан иргэдийг залилсан байна. “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-д ирсэн цахим дарамтын дуудлага 2016 онд 85 байсан бол 2018 онд 229 болж бусад төрлийн хүүхэд хамгааллын дуудлагаас хамгийн их буюу 269%-иар өссөн<sup>3</sup> байна. Мөн Сэтгэцийн

<sup>1</sup> (Харилцаа холбооны зохицуулах хороо. Статистик мэдээ. Улаанбаатар: 2018)

<sup>2</sup> ЦЕГ-ын Мэдээлэл судалгаа, технологийн төв. Статистик мэдээ. Улаанбаатар: 2018.

<sup>3</sup>Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв. Статистик мэдээ. Улаанбаатар: 2018.



эрүүл мэндийн төвд цахим цахим тоглоомонд донтож эмчлүүлсэн хүүхдийн тоо 2013 онд 31, 2014 онд 47, 2015 онд 41, 2016 онд 68, 2017 онд 94 болж тогтмол өсөж байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна.<sup>4</sup>

Иймд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын Хууль эрх зүй хамтын ажиллагааны газар, Сургалт, судалгаа мэдээллийн төв хамтран өсвөр үеийнхний цахим хэрэглээний талаарх мэдлэг, хандлагыг судлах зорилгоор 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ЕБС-ийн 11-17 насны сурагчид болон эцэг эх, багш, нийгмийн ажилтнуудын төлөөллөөс санамсаргүй түүврийн аргаар мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийлээ.

---

<sup>4</sup> Б.Баярмаа, Өсвөр үеийнхний эрүүл мэндийн өнөөгийн байдал, СЭМҮТ, 2018

## 1.2 ЗОРИЛГО

Энэхүү судалгааны зорилго нь өсвөр үеийнхний цахим хэрэглээний түвшин, мэдлэг, хандлагыг тодорхойлон, хүүхдийг цахим хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн нотолгоонд тулгуурласан зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны явцад дараах зорилтуудыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдлыг тогтоох;
- Өсвөр үеийнхний цахим хэрэглээний талаарх мэдлэг, ойлголтын түвшинг тодорхойлох;
- Цахим орчинд хүүхдийн эрхийн зөрчлийн нөхцөл байдлыг судлах;
- Эцэг эх, багш, нийгмийн ажилтнуудын цахим хэрэглээний талаарх мэдлэг, хандлагыг судлах;
- ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт цахим орчны зохистой хэрэглээний талаарх сургалтын модуль, арга зүй байдаг эсэхийг тодруулах;
- Өсвөр үеийнхнийг цахим орчны хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, зөв зохистой ашиглах талаар бодлогод нөлөөлөхүйц зөвлөмж гаргах;

## 1.3 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

ЕБС-ийн 11-17 насны сурагчид, багш, нийгмийн ажилтнууд болон 11 наснаас дээш хүүхэдтэй эцэг эхчүүд судалгаанд хамрагдаж, судалгааны асуулгад хариулсан болно. Харин гэр оронгүй, хараа хяналтгүй хүүхдүүд болон асрах газар, халамжийн төв зэрэг нийтийн байранд амьдарч буй хүүхдүүд хамрагдаагүй юм.

## 1.4 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

21 аймаг болон Нийслэлийн 9 дүүргээс нийт 30 сургуулийг сонгон хамруулсан.

Түүвэрлэлтийн нэгжийг сургуулиар сонгон авсан бөгөөд нэгж сургуулиас 11-17 насны сурагчдын тоог хамгийн багадаа 70 байхаар тооцоолон, сурагчдын нэрсийн жагсаалтаас тохиромжит түүврийн аргаар сонгон асуулга судалгаанд хамруулсан.

Судалгаанд 11-17 насны 2240 хүүхэд, 378 эцэг эх болон ЕБС-ийн 402 багш, нийгмийн ажилтан нийт 3019 хүнийг хамруулсан болно.

## Хүснэгт 1. Түүврийн хэмжээ (нийслэл, аймаг)

№	Аймаг, дүүрэг	Бүгд	Эцэг эх	Сурагчид (11-18 нас)	Багш, нийгмийн ажилтан
<b>Улаанбаатар хот</b>					
1	Багануур	154	20	113	21
2	Багахангай	62	9	43	10
3	Багахангай	167	13	139	15
4	Баянзүрх	143	20	106	17
5	Налайх	191	21	150	20
6	Сонгинохайрхан	186	22	115	49
7	Сүхбаатар	175	23	130	22
8	Хан-Уул	179	18	136	25
9	Чингэлтэй	150	16	123	11
<b>Нийт - Улаанбаатар</b>		<b>1407</b>	<b>162</b>	<b>1055</b>	<b>190</b>
<b>Орон нутаг</b>					
1	Архангай	83	10	63	10
2	Баян-Өлгий	59	10	39	10
3	Баянхонгор	71	7	52	12
4	Булган	77	10	57	10
5	Говь-Алтай	93	15	68	10
6	Говьсүмбэр	75	10	58	7
7	Дархан-Уул	70	10	50	10
8	Дорноговь	84	9	65	10
9	Дорнод	69	9	50	10
10	Дундговь	79	10	59	10
11	Завхан	78	11	54	13
12	Орхон	89	11	67	11
13	Өвөрхангай	53	12	32	10
14	Өмнөговь	79	10	59	10
15	Сүхбаатар	87	10	67	10
16	Сэлэнгэ	82	12	60	10
17	Төв	72	12	50	10
18	Увс	81	9	62	10
19	Ховд	77	9	58	10
20	Хөвсгөл	74	10	55	9
21	Хэнтий	80	10	60	10
<b>Нийт (Орон нутаг)</b>		<b>1612</b>	<b>216</b>	<b>1185</b>	<b>212</b>
<b>Бүгд (УБ +Орон нутаг)</b>		<b>3019</b>	<b>378</b>	<b>2240</b>	<b>402</b>

## 1.5 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-5 -ны хооронд ГБХЗХГ-ын Хууль эрх зүй хамтын ажиллагааны газар болон ССМТ удирдан зохион байгуулж аймаг, дүүргийн ГБХЗ-ын хэлтэс, газрын мэргэжилтнүүд хамтран гүйцэтгэсэн болно.

Судалгааны асуулгыг шалгаж, хүлээн авч мэдээллийг компьютерт шивж оруулах, бүрдэлтийг хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг Сургалт, судалгаа мэдээллийн төв хийж гүйцэтгэсэн.

Тоон судалгааны мэдээллийг шалгаж, хянасны дараа 3019 асуумжийн хуудсыг Excel 2010 программыг ашиглан мэдээллийн бааз үүсгэх, мэдээлэл шивэх, шивэлтийн алдааг хянах зэрэг үйлдлүүдийг гүйцэтгэсний дараа SPSS-20.0 программ руу хөрвүүлэн, улмаар үр дүнгийн тооцооллыг гол гол параметруудийн хүрээнд боловсрууллаа.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ЦАХИМ ХЭРЭГЛЭЭ, ТҮҮНИЙГ ЗӨВ ЗОХИСТОЙ АШИГЛАХ ТАЛААРХИ МЭДЛЭГ, ХАНДЛАГА

### 2.1 СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮД БОЛОН ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН НИЙГЭМ, ХҮН АМ ЗҮЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Судалгаанд 21 аймаг, 9 дүүргийн ЕБС-ийн суурь болон дунд боловсролыг эзэмшихээр суралцаж буй нийт 2240 хүүхэд, 378 эцэг эхчүүдийг тус тус хамрууллаа.

#### Хүснэгт 2. Асуулга судалгаанд хамрагдагсдын хүйсийн үзүүлэлт

Асуулт	Хүүхэд		Эцэг эх	
	Тоо	Хувь	Тоо	хувь
Хүйс				
Эрэгтэй	1301	46.0	126	66.1
Эмэгтэй	1209	54.0	246	33.9

Сурагчдын 54 хувь нь эмэгтэй 46 хувь нь эрэгтэй байна. Эцэг эхчүүдийн 66 хувь нь эмэгтэй, 34 хувь нь эрэгтэй байв.

#### Хүснэгт 3. Асуулга судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн насны үзүүлэлт

Асуулт	Хүүхэд	
	тоо	хувь
Нас:		
11-12	527	23.5
13-14	570	25.5
15-17	1142	51.0

Насны ангиллаар авч үзвэл 50 хувь нь 15-17 насны ц, 2.5 хувь нь 13-15 насны, 24.5 хувь нь 11-12 насны хүүхдүүд байв.

#### Хүснэгт 3. Асуулга судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн насны үзүүлэлт

Асуулт	Эцэг эх	
	Тоо	Хувь
Нас		
30-39	192	50.7
40-49	139	36.8
50 болон түүнээс дээш	47	12.5

Интернетийн хэрэглээний талаарх судалгаа тул залуу эцэг эхчүүдийг түлхүү хамруулахыг зорьсон ба 12-оос дээш насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн дийлэнх буюу

43 хувь нь 35-44 насныхан, багш нарын зонхилох буюу 50.7 хувийг 25-34 насныхан эзэлж байв.


### Хүснэгт 3. Асуулга судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдийн ажилладаг салбар

Асуулт	Эцэг эх	
Салбар:	тоо	хувь
Төрийн байгууллага	194	52.2
Хувийн хэвшил	50	13.4
Олон улсын байгууллага	6	1.6
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	62	16.7
Тэтгэвэрт	25	6.7
Ажилгүй	35	9.4

Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 90 гаруй хувь нь ямар нэг ажил эрхэлдэг бөгөөд 52.2 хувь нь төрийн байгууллагад, 16.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 13.4 хувь нь хувийн байгууллагад ажиллаж байна.


## 2.2 ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЦАХИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

График 1. Өсвөр үеийнхний цахим хэрэглээ, хувиар



Судалгаанд улсын болон хувийн хэвшлийн хот, хөдөөгийн нийт 30 сургуулийн 11-17 насны 2242 хүүхэд хамрагдсанаас 53 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байлаа. Асуулгад оролцсон арван хүүхэд тутмын ес нь интернет хэрэглэдэг байв. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны статистик мэдээнд манай улсын 15-60 насны арван хүн тутмын найм нь ямар нэгэн байдлаар сошиал медиа ашигладаг гэсэн байна.<sup>5</sup> Эндээс үзэхэд өсвөр насныхны цахим хэрэглээ насанд хүрэгчдийнхээс 10 пунктээр илүү байгаа нь илэрхий байна.


График 2. Өсвөр үеийнхний интернет хэрэглэж буй шалтгаан, хувиар



Хүүхдүүд найз нөхдийн харилцаа (46.3%), мэдээллийг цаг алдалгүй хүлээж авах, мэдлэг чадвараа нэмэгдүүлэх (20.4%) хичээлийн холбогдолтойгоор (13.9%) зорилгоор цахим хэрэглэгдэхүүн ашиглаж интернет сүлжээг ихэвчлэн хэрэглэж байна.


<sup>5</sup> Харилцаа холбооны зохицуулах хороо. Статистик мэдээ. Улаанбаатар: 2018.

**График 3. Интернетийн хэрэглээний эх үүсвэр**



Хүүхдүүдийн дийлэнх нь буюу 99 хувь нь гар утасны дата болон гэрийн WiFi-гаар интернетэд холбогддог гэж хариулснаас үзвэл тэдний цахим хэрэглээнд хяналт тавих, хэрэглээг зөв зохистой хязгаарлах боломж байгааг харуулж байна.


**График 4. Ямар төхөөрөмжөөр интернетэд холбогдох байдал**



Сурагчдын дийлэнхи нь буюу 84.4 хувь нь ухаалаг утас хэрэглэж байна. Тэдгээр хүүхдийн 95 хувь нь интернет хэрэглэдэг, 92 хувь нь нүүр номын хаягтай байв.




**График 5. Өдөрт дунджаар хэдэн цаг интернет хэрэглэдэг вэ?**



<sup>4</sup>Судалгаанд оролцсон гурван хүүхэд тутмын нэг нь өдөрт нэг хүртэлх цаг интернет хэрэглэдэг гэж хариулсан нь зохистой хэрэглээ гэж үзэж болохоор байна. Учир нь олон улсын судалгаагаар өсвөр насны хүүхдүүд өдөрт 15-45 минут интернет ашиглах нь зохистой гэдгийг баталсан байна. Түүнчлэн гурван хүүхэд тутмын нэг нь 2 хүртэлх цаг, 3 хүүхэд тутмын нэг нь 2-оос дээш цаг интернет хэрэглэдэг байна.

**График 6. Түгээмэл хэрэглэдэг аппликейшны төрлүүд (давхардсан хариултаар)**




Хамгийн түгээмэл ашигладаг нийгмийн сүлжээгээр сурагчдын дийлэнх нь буюу 85 хувь нь фейсбүүк, 41.6 хувь нь ютүүб, 17.3 хувь нь инстаграммыг тус тус нэрлэжээ. Фэйсбүүк, инстаграмм хэрэглэгчийн насны доод хязгаар нь 13 нас буюу түүнээс дээш байдаг. Гэтэл судалгаанд хамрагдсан 11-12 насныхны 70 гаруй хувь нь фейсбүүк, 6 хувь нь инстаграммыг хамгийн түгээмэл ашигладаг гэж хариулсан нь тэд дээрх нийгмийн сүлжээнд бүртгүүлэхдээ насаа нэмж бүртгүүлдэг болохыг гэрчилж байна. Түүнчлэн 10 хувь нь цахим тоглоом тоглох зорилгоор интернет ашигладаг гэж хариулсан ба 2013-2017 оны хооронд Сэтгэцийн эрүүл мэндийн төвд 281 хүүхэд цахим цахим тоглоомонд донтож эмчлүүлсэн нь<sup>6</sup> сэтгэл эмзэглүүлж байна.

<sup>6</sup> Б.Баярмаа, Өсвөр үеийнхний эрүүл мэндийн өнөөгийн байдал, СЭМҮТ, 2018


## 2.3 ӨСВӨР ҮЕ БОЛОН ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ЦАХИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА

График 7. Өсвөр үеийнхний интернет ашиглахыг сурсан байдал




Сурагчдын дийлэнх буюу 84.5 хувь нь интернет ашиглахыг өөрөө болон найз нөхдөөсөө сурсан бол дөнгөж 4.2 хувь нь хичээлээр л энэ талын мэдлэгийг олж авсан гэж хариулжээ. Энэ нь ЕБС-ын мэдээллийн технологийн хичээлээр энэ талын зөв мэдлэг хангалттай хэмжээнд өгч чадахгүй байгааг харуулж байна.

График 8. Цахим орчинд хүүхдийн дотны туслагч




Цахим орчинд хүүхдүүдийн хамгийн дотных нь туслагч нь үе тэнгийн найз нөхөд гэж дийлэнх буюу 61.8 хувь хариулсан байхад сургуулийн багш, нийгмийн ажилтан гэж дөнгөж 8.7 хувь нь үзсэн нь хүүхдийн эрхийг ханган хэрэгжүүлэхэд үүрэг хүлээгчид, ялангуяа тэдний хоёрдахь гэр болсон ЕБС цахим хэрэглээний мэдлэг ойлголтыг өгөх талаарх үйлчилгээг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

**График 9. Цахим орчинд хувийн нууц мэдээллээ хамгаалах тохиргооны мэдлэгийн түвшин, хувиар**



Хүүхэд болон эцэг эхчүүдийн гурван хүн тутмын нэг нь цахим орчинд хувийн нууц мэдээллээ хамгаалах тохиргоо хийх мэдлэг чадвар огт байхгүй байна. Тэдний дунд түвшний мэдлэг ойролцоо байхад ахисан түвшний мэдлэг эцэг эхээсээ 3 дахин их байна. Үүнээс үзэхэд хүүхдийн өмнө үүрэг хүлээсэн асран хамгаалагч, эцэг эхчүүдийн цахим орчны мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна.

**График 10. Эцэг эхчүүдийн цахим орчны шүүлтүүрийн программ хангамжийн мэдлэг, хувиар**




Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийг гэр бүлийн орчин дахь боловсролоор дамжуулан цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах үүрэг хүлээдэг. Гэтэл тэдний дийлэнх буюу 94 хувь нь интернет орчны шүүлтүүрийн программ хангамжийг ашиглах чадвар огт байхгүй байв.

**График 11. Хүүхдүүд фейсбүүкийн хэдэн хаяг ашигладаг эсэх, хувиар**



Сошиал орчинд Фейсбүүк хэрэглэдэг гурван хүүхэд тутмын нэг нь хоёр ба түүнээс дээш хаягтай байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Элдэв санаагүй хүүхдүүд олон хаяг нээх нь хувийн мэдээллээ бусдад алдах, үүнээс болж бусдад ямар нэг хэлбэрээр хүчирхийлэл, тохуурхалд өртөх зэрэг эрсдэлд оруулж болзошгүй. Нөгөө талаар олон хаягтай байх нь санамсаргүй үйлдэл биш бөгөөд цахим орчинд хэн нэгнийг гутаан доромжилсон, садар самуунд уруу татсан, татагдсан, гэмт хэргийн шинжтэй аливаа үйлдлүүд нь ихэвчлэн өөрийн нэр хаяг, зураггүй профайлаас үйлдэгдэж байгаа тул фейсбүүкийн хуурамч хаягуудыг Монгол улс нэн даруй хориглох шаардлага амьдралаас урган гарч байгааг дурдах нь зүйтэй.

**График 12. Хүүхдүүд цахим орчинд танихгүй хүнтэй чаталж байсан эсэх, хувиар**




Гурван хүүхэд тутмын нэг нь интернетээр танихгүй хүнтэй танилцаж байсан гэж хариулсан нь сүүлийн жилүүдэд цахим хэрэглээ өргөжихийн хэрээ интернет болзоо нь зөвхөн насанд хүрэгчдэд хамаатай асуудал биш болсныг харуулж байна.

**График 13. Найзуудаа цахим орчинд шоолж тоглох дүрс бичлэг оруулж байсан эсэх, хувиар**



Дөрөв нь хүүхэд тутмын нэг нь үе тэнгийн найз нөхдөө цахим орчинд шоолж тоглосон дүрс бичлэг оруулж байсан гэж үзсэн нь цахим орчны зөв зохистой хэрэглээний мэдлэг, ойлголт тэдэнд дутагдаж байгааг харуулж байна.


**График 14. Хүүхдүүд найзын хүсэлт авахдаа хэнийг нэмдэг вэ, хувиар**



Фейсбүүк хэрэглэхдээ таван хүүхэд тутмын нэг нь таньдаггүй хүний найзын хүсэлтийг хүлээж авдаг байна. Энэ нь хувийн мэдээллээ бусдад алдах үүнээс болж өөрийгөө ямар нэг хэлбэрээр эрсдэлд оруулж болзошгүй байна.


## 2.4 ЦАХИМ ОРЧНЫ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ

График 15. Фейсбүүкээр зүй бус утгатай зурвас и-мэйл авч байсан эсэх, хувиар




Хүүхдүүдийн 82 хувь нь зүй бус утгатай зурвас и-мэйл, фейсбүүкийн хэрэглэгчдээс авч байсан гэж үзсэн бол эцэг эхчүүдийн 93 хувь нь хүүхдээ цахим дарамт, дээрэлхэлтэнд өртөж байсан гэж хариулсан нь цахим орчинд хүүхдийн эрх ноцтой зөрчигдөх болсныг гэрчилж байна. Түүнчлэн зүй бус зурвас, и-мэйлийн агуулгад гутаан доромжилж нэр төрд халдаж, дарамталсан, хувийн мэдээллийг нууцыг задруулсан, гэмт хэрэгт уруу татах зэрэг үйлдлүүд зонхилж байна.

График 16. Садар самууныг сурталчилсан мэдээлэлтэй тааралдаж байсан эсэх, хувиар




Хүүхдүүдийн 43 хувь нь садар самууныг сурталчилсан агуулга бүхий мэдээлэлтэй тааралдаж байсан гэж хариулжээ. Өсвөр насныхан нь аливаа зүйлийн үр дагавар нь ямар байхыг нягталж үзэлгүйгээр хийж үзэхийг эрмэлздэг ба сониуч байдлаар тэдгээр линкээр нэвтэрч хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүний наймааны золиос болох эрсдэл өндөр байна.

**График 17. Эцэг эх, асран хамгаалагчаас интернетийн байгууллага гэрээ байгуулахдаа насанд хүрээгүй хүн байгааг асуусан эсэх, хувиар**



Интернетийн байгууллага хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа насанд хүрээгүй хүн байгаа эсэхийг дөнгөж 16.1 хувь нь лавлаж асуусан бол 84 гаруй хувь нь асуугаагүй болон санахгүй байна гэж хариулжээ. Иймд интернетийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийг шүүгч программ хангамжаар үйлчлэх хууль, журмаар хүлээсэн үүргийг заавал хэрэгжүүлж, асран хамгаалагчид тайлбарлаж таниулах шаардлагатай байна.

**График 18. Цахим орчинд хүчирхийлэлд өртвөл хэнд хандах вэ, хувиар**




Эцэг эхчүүдийн үзсэнээр хүүхэд нь цахим хүчирхийлэлд өртвөл 92 хувь нь гэрийнхэндээ энэ тухайгаа хэлдэг гэж хариулсан нь сайшаалтай боловч энэ асуултыг хүүхдээс өөрөөс нь асуухад дөнгөж 36 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хэлнэ гэж хариулжээ. Энэ нь цахим орчинд аливаа хүчирхийлэлд өртсөн гурван хүүхэд тутмын нэг нь л болсон явдлыг эцэг эхдээ хэлдэг болох нь судалгаанаас ажиглагдаж байна.

**График 19. Эцэг эх интернет хэрэглээний цаг агуулгад хяналт тавьдаг эсэх, хувиар**



Хүүхдийнхээ цахим хэрэглээнд эцэг эхчүүдийн 82 хувь нь их бага хэмжээнд хяналт тавьдаг нь гэсэн боловч цахим сүлжээ хэрэглэх мэдлэг, чадвар маш муу байлаа.

**График 20. Цахим орчинд гутаан доромжлуулах, ялгаварлан гадуурхагдвал хэнд хандах вэ, хувиар**



Цахим орчинд хэн нэгэнд гутаан доромжлуулах, ялгаварлан гадуурхагдвал 36.1 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандана, 32.4 хувь нь найз нөхөдтэйгээ зөвлөлдөн гэж үзсэн байхад сургуулийн багш, нийгмийн ажилтанд хандана гэж ердөө 3-хан хувь нь хариулжээ.




**График 21. Сурагчдад зориулсан цахим хэрэглээний модуль хөтөлбөр байдаг эсэх, хувиар**



Багш, нийгмийн ажилтнуудын дөрвөн хүн тутмын гурав нь сургуулийн орчинд сурагчдад зориулсан цахим хэрэглээний модуль, хөтөлбөр байхгүй болон мэдэхгүй гэж үзсэн нь ерөнхий боловсролын сургуулиудад энэ талын нэгдсэн, хүртээмжтэй сургалтын хөтөлбөр, арга зүй хангалтгүй байгааг илтгэж байна.

**График 22. Гар утасны дугаарын бүртгэл, хувиар**



Гурван хүүхэд тутмын нэгнийх нь гар утасны дугаар өөр хүний нэр дээр бүртгэлтэй байна. Гар утасны дугаарыг хүүхдийн нэр дээр бүрэн бүртгэлжүүлснээр хориглосон буюу сөрөг нөлөө бүхий мэдээлэл хүлээн авахаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ


1. Судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн интернетийн хэрэглээ маш өндөр байгаа харагдлаа. Тэдний нас ахих тусам цахим хэрэглээний түвшин нэмэгдэж байв
2. Сурагчдын дийлэнхи буюу 85 орчим хувь нь ухаалаг утас хэрэглэдэг, тэдний 92 хувь нь нүүр номын хаягтай байв. Эндээс үзэхэд ухаалаг утас авах нь тийм ч хүндрэлтэй асуудал биш гэдэг нь харагдаж байна.
3. 70 гаруй хувь нь өдөрт 1-2 цагийг цахим орчинд өнгөрүүлдэг ба тэдэнд ихэнх тохиолдолд аливаа асуудал тулгарахад хамгийн дотны туслагч нь найз нөхөд, үе тэнгийнхэн байдаг байна.
4. Гурван хүүхэд тутмын нэг нь цахим орчны хувийн нууц мэдээллээ хадгалах тохиргоог огт мэддэггүй бөгөөд эцэг эхчүүдийн энэ талын мэдлэг нь хүүхдээсээ муу байв.
5. Хоёр хүүхэд тутмын нэг нь садар самууныг сурталчилсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, таван хүүхэд тутмын дөрөв нь цахимаар зүй бус утгатай зурвас авдаг ба эцэг эхчүүдийн ийм төрлийн сөрөг мэдээллийг шүүх программ хангамжийг ашиглах чадвар 95 хувьд нь огт байхгүй байна.
6. Интернетийн байгууллага хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа насанд хүрээгүй хүн байгаа эсэхийг 84 гаруй хувь нь асуугаагүй байна. Интернетийн компаниуд бага насны хүүхэдтэй айлд сөрөг мэдээллийг шүүгч программыг заавал суулгуулах шаардлагатайг мэдээлэх үүргээ биелүүлэхгүй, нийгмийн хариуцлагаа ухамсарлахгүй байна.
7. Гурван хүүхэд тутмын нэгнийх нь гар утасны дугаар өөр хүний нэр дээр бүртгэлтэй байна. Гар утасны дугаарыг хүүхдийн нэр дээр бүрэн бүртгэлжүүлснээр хориглосон буюу сөрөг нөлөө бүхий мэдээлэл хүлээн авахаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИАС ӨСВӨР ҮЕИЙНХЭД ЦАХИМ ОРЧНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР МЭДЛЭГ ОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Энэхүү бүлэгт нэгдүгээрт, ерөнхий боловсролын сургуулиас өсвөр үеийнхэнд цахим орчны зохистой хэрэглээний талаар мэдлэг олгож буй өнөөгийн байдал, хоёрдугаарт багш, нийгмийн ажилтнуудын цахим орчны талаарх мэдлэг, хандлагыг судлан тогтоолоо.

### 3.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ ШИНЖ

График 23. Байршил, хувиар



Судалгаанд улсын болон хувийн хэвшлийн хот, хөдөөгийн нийт 30 сургуулийн 404 ерөнхий боловсролын сургуулийн багш, нийгмийн ажилтнууд хамрагдсанаас 53 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байлаа.

#### Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан багш, нийгмийн ажилтнуудын ерөнхий шинж, хувиар

№	Сонгосон үзүүлэлт	Хувийн жин	Багш, нийгмийн ажилчдын тоо
1.	Насны бүлэг		
1.1	24 хүртэлх	0.8	3
1.2	25-34	50.7	203
1.3	35-44	31.1	126
1.4	45-54	14.0	56
1.5	55 дээш	4.0	16
2.	Хүйс		
2.1	Эрэгтэй	25.9	106
2.2	Эмэгтэй	74.1	298
3.	Албан тушаал		
3.1	Багш	94.0	379
3.2	Нийгмийн ажилтан	6.0	25

Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл 25 хүртэлх насны оролцогчид 3 (0.8%), 25-34 насны 203 (50.7%), 35-44 насны 126 (31.1), 45-аас дээш насны 72 (18%) багш, нийгмийн ажилтнууд хамрагдсан бөгөөд насны бүлгээс харахад ерөнхий

боловсролын сургуульд ажиллагчдын дийлэнх буюу 81.8 хувь нь 25-44 насныхан байгаа нь ажиглагдлаа.

Хүйсийн ялгаатай байдлаар авч үзвэл 74.1 хувь (298) нь эмэгтэй 25.1 хувь (106) нь эрэгтэй багш, нийгмийн ажилтнууд байлаа. Эмэгтэй хүн давамгайлж байгаа нь багшийн мэргэжлийн онцлогтой холбоотой гэж үзэж болно.

Албан тушаалын хувьд 94.0 хувь (379) нь багш, 6 хувь (25) нь нийгмийн ажилтан нар тус тус хамрагдлаа.

### 3.2 ЦАХИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААРХ СУРГУУЛИЙН БАГШ, НИЙГМИЙН АЖИЛТНУУДЫН МЭДЛЭГ, ХАНДЛАГА

График 24. Цахим орчинд хувийн нууцаа хамгаалах тохиргооны мэдлэгийн түвшин, хувиар



Хоёр багш, нийгмийн ажилтан тутмын нэг нь цахим орчинд хувийн мэдээллээ нууцлах тохиргооны талаар ахисан болон дунд түвшний мэдлэгтэй, гурван багш тутмын нэг нь анхан шатны мэдлэгтэй байв. Цөөн хувь нь буюу 15 хувь нь энэ талын мэдлэг, чадвар огт байхгүй гэж хариулжээ.

График 25. Цахим орчны шүүлтүүрийн программ хангамжийг ашигладаг эсэх, хувиар




Багш нар цахим орчны шүүлтүүрийн программ хангамжийн талаар 96.8 хувь буюу дийлэнх нь ашиглах чадвар байхгүй байгаа нь тэдэнд энэ талын мэдлэг боловсрол олгох шаардлагатайг харуулж байна.

**График 26. цахим орчны зохисгүй хэрэглээний талаар сурагчид зөвлөгөө авдаг эсэх, хувиар**



Багш нарын үзсэнээр сурагчдын 61 орчим хувь нь цахим орчны зохисгүй хэрэглээний талаар байнга болон заримдаа зөвлөгөө авдаг байна.

**График 27. Цахим орчинд хүүхэд хүчирхийлэлд өртвөл та өөрийгөө зөвлөгөө өгөх чадвартай эсэх, хувиар**



Багш, нийгмийн ажилтнуудын гурван хүн тутмын нэг нь энэ талын зөвлөгөө өгөхөд бэлэн биш өөртөө итгэх итгэл сул байгаа нь илэрхий байна. Түүнчлэн сурагчдад зөвлөгөө өгөх чадваргүй гэж үзсэн багш нарын дийлэнхи буюу 70 орчим хувь нь орон нутгийн багш нар байгаа тул тэдэнд чиглэсэн сургалтыг түлхүү хийх хэрэгцээ байна.


**График 28. Зөвлөгөө өгөх чадваргүй гэж хариулсан багш нарын шалтгаан, хувиар**



Сурагчдад цахим орчны зохистой хэрэглээний талаар зөвлөгөө өгөх чадваргүй гэж хариулсан багш, нийгмийн ажилтнуудын дийлэнх нь уг шалтгаанаа цахим орчны зөв хэрэглээний талаар тусгайлсан модуль, хөтөлбөр байхгүйгээс энэ талын зөвлөгөө өгөхөд бэлэн биш гэж үзсэн байна.

### 3.3 ЕБС-д цахим орчны эрсдлийг таниулах, урьдчилан сэргийлэх талаар хичээл явуулах болон сургалтын материал байгаа эсэх

График 29. Сургалтын модуль, хөтөлбөр, гарын авлага байдаг эсэх, хувиар



ЕБС-д өсвөр насны хүүхдүүдэд цахим орчны аливаа эрсдлийг таниулах, урьдчилан сэргийлэх талаар хичээл явуулах арга зүйн болон сургалтын материал байгаа эсэхийг тодруулахад дөнгөж 27.4 хувь нь байгаа гэж хариулжээ. Эндээс үзэхэд ерөнхий боловсролын сургуулийн багш нарт өсвөр насны хүүхдүүдэд зориулсан цахим орчны аюулгүй байдлын талаарх сургалтын гарын авлага, материал хангалттай бус гэж дүгнэж болохоор байна.

График 30. ЕБС-д сурагчдад цахим орчны зохистой хэрэглээний талаархи мэдлэг олгох багш бэлтгэх хэрэгцээтэй эсэх, хувиар



ЕБС-ийн сурагчдад цахим орчны аюулгүй байдал, зохистой хэрэглээний талаар зөв мэдлэг, чадвар олгох багш бэлтгэх шаардлагатай гэж судалгаанд хамрагдсан багш, нийгмийн ажилтнуудын 81 хувь нь үзсэн байв.

## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Хоёр сурагч тутмын нэг нь багшаасаа цахим орчны зохисгүй хэрэглээний талаарх зөвлөгөөг байнга болон заримдаа авдаг хэдий ч ЕБС-ийн гурван багш тутмын нэг нь сурагчдад энэ талын зөвлөгөө өгөхөд бэлэн биш гэж өөрийгөө дүгнэсэн байв.
2. Багш нар цахим орчны шүүлтүүрийн программ хангамжийг 97 хувь нь огт ашигладаггүй байна.
3. ЕБС-д өсвөр насны хүүхдүүдэд цахим орчны аливаа эрсдлийг таниулах, урьдчилан сэргийлэх талаар хичээл явуулах арга зүйн болон сургалтын материал дийлэнхэд нь байхгүй байна. Иймээс цаашид сурагчдад цахим орчны зөв хэрэглээ, аюулгүй байдлын талаархи мэдлэг олгох багш бэлтгэх шаардлагатай гэж 80 орчим хувь нь үзсэн байна.



## ДҮГНЭЛТ

Өсвөр үеийнхний 92 хувь нь интернет хэрэглэдэг ба хэрэглэдэггүй гэсэн хариултын дийлэнх буюу 76 хувь нь орон нутгийн хүүхдүүд эзэлж байгаа бөгөөд үүнд 11-12 насныхан зонхилж байна. Хүүхдүүдийн 85 орчим хувь нь ухаалаг утас хэрэглэдэг, тэдний 92 хувь нь нүүр номын хаягтай байв. Эндээс үзэхэд ухаалаг утас авах нь тийм ч хүндрэлтэй асуудал биш гэдэг нь харагдаж байна.

Хамгийн түгээмэл ашигладаг нийгмийн сүлжээгээр дийлэнх нь буюу 85 хувь нь фейсбүүкийг нэрлэжээ. Фейсбүүк, инстаграмм хэрэглэгчийн насны доод хязгаар нь 13 буюу түүнээс дээш байдаг. Гэвч судалгаанд хамрагдсан 11-12 насныхны 70 гаруй хувь нь фейсбүүк, 6 хувь нь инстаграммыг хамгийн түгээмэл ашигладаг гэж хариулсан нь тэд дээрх нийгмийн сүлжээнд бүртгүүлэхдээ насаа нэмж бүртгүүлдэг болохыг гэрчилж байна. Иймд хүүхдийн гар утасны дугаарын бүртгэлийг сайжруулснаар фейсбүүкийг и-мэйл хаягаар нээдэггүй зөвхөн гар утасны хаягаар нээдэг болгох боломжтой гэж үзэж байна. Түүнчлэн 10 хувь нь цахим тоглоом тоглох зорилгоор интернет ашигладаг гэж хариулсан ба 2013-2017 оны хооронд Сэтгэцийн эрүүл мэндийн төвд 281 хүүхэд цахим тоглоомонд донтож эмчлүүлсний дийлэнх нь хөвгүүд байна<sup>7</sup>. Цахим тоглоомонд донтох асуудал нь эцэг эхийн хараа хяналт дутмаг байдгаас гадна хүүхэд залууст чөлөөт цагаа зөв зохистой өнгөрөөх газар хомс байгаатай холбоотой гэж үзэж болно.

Сурагчдын 70 гаруй хувь нь өдөрт 1-2 цаг, 30 хувь нь 2 ба түүнээс дээш цагийг цахим орчинд өнгөрүүлдэг ба тэдэнд аливаа асуудал тулгарахад ихэнхи тохиолдолд хамгийн дотны туслагч нь найз нөхөд, үе тэнгийнхэн нь байдаг байна. Олон улсын судалгаагаар өсвөр насны хүүхдүүд өдөрт 15-45 минут интернет ашиглах нь зохистой гэж зөвлөсөн ба энэ жишгээр авч үзвэл бараг хоёр хүүхэд тутмын нэг нь интернетийг зохистой хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэж байна гэж үзэж болохоор байна.

Фейсбүүк хэрэглэдэг гурван хүүхэд тутмын нэг нь хоёр ба түүнээс дээш хаягтай байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Элдэв санаагүй хүүхдүүд олон хаяг нээх нь хувийн мэдээллээ бусдад алдах, хүчирхийлэл, тохуурхалд өртөх зэрэг эрсдэлд оруулж болзошгүй. Нөгөө талаар олон хаягтай байх нь санамсаргүй үйлдэл биш бөгөөд цахим орчинд хэн нэгнийг гутаан доромжилсон, садар самуунд уруу татсан, татагдсан, гэмт

<sup>7</sup> Б.Баярмаа, Өсвөр үеийнхний эрүүл мэндийн өнөөгийн байдал, СЭМҮТ, 2018

хэргийн шинжтэй аливаа үйлдлүүд нь ихэвчлэн өөрийн нэр хаяг, зураггүй профайл хаягнаас үйлдэгдэж байгаа тул фейсбүүкийн хуурамч хаягуудыг нэн даруй устгах шаардлагатай байна.

Түүнчлэн таван хүүхэд тутмын дөрөв нь зүй бус утгатай зурвас мэйл фейсбүүкийн хэрэглэгчээс авч байсан, хоёр хүүхэд тутмын нэг нь садар самууныг сурталчилсан агуулга бүхий мэдээлэлтэй тааралдаж байсан гэж хариулсан нь сөрөг мэдээллийг шүүгч программыг эцэг эхчүүд хүүхдийнхээ компьютер, гар утсыг интернэтэд холбуулахдаа заавал суулгуулах шаардлагатайг харуулж байна.

Өсвөр үеийнхэнд цахим орчны зохистой хэрэглээний талаарх мэдлэгийг тогтмол олгох нь чухал чухал бөгөөд гурван хүүхэд тутмын нэг нь хувийн мэдээллээ нууцлах тохиргоог огт мэдэхгүй бөгөөд сошиал медиагаар танихгүй хүнтэй танилцаж байсан, таван хүүхэд тутмын нэг нь найзын хүсэлт авахдаа танихгүй хүнийг найзаараа нэмдэг, дөрөв нь сурагч тутмын нэг нь үе тэнгийн найз нөхдөө шоолж цахим орчинд дүрс бичлэг оруулж байжээ.

Эцэг, эхчүүдийн 80 орчим хувь нь хүүхдийнхээ интернетийн хэрэглээнд их бага хэмжээнд хяналт тавьдаг гэсэн хэдий ч тэдний 95 орчим хувь нь цахим орчны шүүлтүүрийн программ хангамжийг ашиглах чадваргүй, 40 хувь нь цахим орчинд хувийн мэдээллээ нууцлах тохиргооны мэдлэг огт байхгүй байна. Түүнчлэн хүүхэд нь цахим хүчирхийлэлд өртвөл 92 хувь нь гэрийнхэндээ энэ тухайгаа хэлдэг гэж эцэг, эхчүүд хариулсан хэдий ч энэ асуултыг хүүхдээс өөрөөс нь асуухад дөнгөж 36 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хэлнэ гэж хариулжээ. Энэ нь цахим орчинд аливаа хүчирхийлэлд өртсөн гурван хүүхэд тутмын нэг нь болсон явдлыг эцэг эхдээ хэлдэг болохыг харуулж байна.

Интернетийн байгууллага хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа насанд хүрээгүй хүн байгаа эсэхийг огт асуугаагүй гэж эцэг эхчүүдийн 85 хувь нь хариулсан нь интернетийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуй нэгжүүд шүүгч программ хангамжаар үйлчлэх хууль, журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, асран хамгаалагчдад тайлбарлаж таниулах байдал маш хангалтгүй байгаа нь илэрхий байв.

Ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл технологийн хичээлийн хөтөлбөр, агуулгыг сайжруулах шаардлагатай байна. Учир нь хүүхдүүд анх интернет ашиглахыг 84.5 хувь нь өөрөө болон найз нөхдөөсөө, 11.3 хувь нь эцэг эхээсээ, 4.3 хувь нь

хичээлээр энэ талын мэдлэгийг олж авсан гэж хариулсан байв. Багш нийгмийн ажилтнууд цахим орчны зохисгүй хэрэглээний талаар арван сурагч тутмын нэг нь байнга зөвлөгөө авдаг хоёр сурагч тутмын нэг нь заримдаа зөвлөгөө авдаг гэж хариулсан хэдий ч гурван багш тутмын нэг нь өөрийгөө энэ талын зөвлөгөө өгөх мэдлэг, чадвар байхгүй гэж үнэлсэн байна. Энэ нь ЕБС-д өсвөр насны хүүхдүүдэд цахим орчны аливаа эрсдлийг таниулах, урьдчилан сэргийлэх талаар хичээл явуулах арга зүйн болон сургалтын материал 75 гаруй хувьд нь байхгүй гэж үзсэнтэй холбоотой. Иймээс ЕБС-иуд өсвөр насны хүүхдүүдэд зориулсан цахим орчны зохистой хэрэглээний талаарх сургалтын гарын авлага, материал, модуль хөтөлбөртэй болох хэрэгцээ, шаардлага үгүйлэгдэж байна.

Цаашид өсвөр насныхны хувьд цахим орчин нь нэгэнт хэрэглээ болсон тул шууд хязгаарлахаас илүүтэй ухаалаг хэрэглээг зүй зохистой хэрэглэх талаар сургалт, сурталчилгаа хийх, сургалтын хөтөлбөрт тусгах, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад цахим хэрэглээ, сэтгэл зүйн зөв дадал, ухаалаг хэрэгцээний талаар сургалт, үйл ажиллагааг хөтөлбөрөөр оруулах, сөрөг мэдээллийг шүүгч программ хангамжийн мэдлэгийг олон нийтэд, оновчтой сувгаар тогтмол олгох нь үр дүнтэй гэж үзэж байна.

## **БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ**

**Нэг. Цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах үр дүнтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр:**

- Цахим орчинд хүүхэд хамгаалах хуультай болох эсвэл холбогдох эрх зүйн баримтыг шинэчлэх;
- Зохисгүй агуулга, хууль бус контентын албан ёсны тодорхойлолтыг холбогдох эрх зүйн баримт бичигт тусгаж оруулах;
- Иргэдээс ирсэн гомдол хүсэлтийн дагуу хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө бүхий мэдээллийг тодорхойлдог бие даасан зөвлөл байгуулан ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Хүүхдийн цахим орчны зохистой хэрэглээний стандарт гаргах, сөрөг нөлөөтэй мэдээллийг насны ангилалд тохируулан ялгамжтай, оновчтой тодорхойлох;
- Хүүхдийн эсрэг чиглэсэн аливаа төрлийн хүчирхийлэл, хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө бүхий мэдээллийг зориуд түгээхтэй холбоотой хууль бус үйлдлийг шуурхай таслан зогсоох, шалган шийдвэрлэх, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлэх;

**Хоёр. Хоёр. Цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх олон нийтэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээний талаар:**

- Хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө бүхий мэдээ, мэдээллийг олон нийтэд нээлттэй түгээхийн өмнө тэдгээр мэдээллийг хүлээн авч болох насны хязгаарын талаар урьдчилан тогтмол мэдээллэх, мэдээллийн бүтээгдэхүүнд хүүхдийн насны ангилалд тохирох тэмдэг, тэмдэглэгээ байршуулж хэвших;
- Ерөнхий боловсролын сургуулийн зохих шатны сургалтын хөтөлбөрт цахим орчны зөв зохистой хэрэглээний талаархи сэдвийг тусгаж хэрэгжүүлэх;
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн контентуудыг тогтмол бэлтгэж олон нийтэд хүргэх;

- Хүүхдүүдийн цахим хэрэглээг зохистой байлгахад тэдэнд зориулсан хангалттай контентийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд МҮОНРТ энэ төрлийн үйл ажиллагаанд идэвх санаачлагатай хандах;
- Интернетийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийг шүүгч программ хангамжаар үйлчлэх хуулиар хүлээсэн үүргийг заавал хэрэгжүүлж, асран хамгаалагчид тайлбарлаж таниулах;
- Шүүгч программ хангамжийг бүх нийтээр хэрэглэх боловсролыг олгох;
- Цахим орчны зохистой хэрэглээний талаархи мэдлэг, мэдээлэл олгох сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах, хүүхэд болон эцэг эхчүүд, олон нийтэд зориулсан сургалтын модуль боловсруулах;
- Хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх дугуйлан, секц, клуб, хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хөгжүүлэх;

#### **Техник технологийн чадавхийг нэмэгдүүлэхэд:**

- Эцэг эхчүүдэд зориулсан контент шүүлтүүрийн программ хангамжийг монгол хэл дээр хөгжүүлэх;
- Цахим орчинд өөрийн нэр, зураггүй фейсбүүкийн хуурамч хаягуудыг устгах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран судалж, хэрэгжүүлэх;
- Үүрэн холбооны операторуудтай хамтарч хүүхдийн гар утасны дугаарыг бүртгэлжүүлснээр насанд нь тохироогүй зохисгүй контентийг автоматаар хаах техникийн боломжийг бүрдүүлэх;
- Хүүхдэд зориулсан эерэг цахим сайтуудыг болон эцэг эхчүүд, сурган хүмүүжүүлэгчдэд зориулсан гарын авлага, шаардлагатай мэдээллийг агуулсан цахим сайтыг олноор бий болгох;

## ХАВСРАЛТ 1. АСУУЛГЫН ХУУДАС

### ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДЭЭС АВАХ АСУУЛГА

Таны мэдээллийн нууцыг “Хувь хүний нууцын тухай” Монгол Улсын хууль болон “Статистикийн тухай” Монгол улсын хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу нууцлан хадгална. Та энэхүү судалгаанд үнэн зөв хариулт өгч оролцсоноор хүүхдийг цахим хүчирхийллээс хамгаалахад шаардлагатай үндсэн мэдээллийг бүрдүүлэх болно.

№	Асуулт	Хариултын кодууд	Алхам
1	Байршил	Хот /аймаг/..... Сум /Дүүрэг/.....	
2	Нас	11-12	1
		13-14	2
		15-17	3
3	Хүйс	Эрэгтэй	1
		Эмэгтэй	2
4	Та интернет хэрэглэдэг үү ?1	Тийм	1
		Үгүй	2 → Дуусгах
5	Та интернет ашиглахыг хэнээс суралцсан бэ ?	Өөрөө	1
		Найз нөхөд	2
		Эцэг эх	3
		Хичээлээр	4
6	Цахим орчинд зөвлөгөө, мэдээлэл хэрэгтэй үед хэн таны дотны туслагч вэ ?	Эцэг эх, гэр бүлийн гишүүд	1
		Багш, нийгмийн ажилтан	2
		Найз нөхөд, үе тэнгийнхэн	3
		Бусад	4
7	Өдөрт дунджаар хэдэн цаг интернет хэрэглэдэг вэ ?	1 хүртэлх цаг	1
		1-2 цаг хүртэл	2
		2-4 цаг хүртэл	3
		4 болон түүнээс дээш цаг	4
8	Ямар төхөөрөмж ашиглан интернет хэрэглэдэг вэ ?	Ухаалаг утас	1
		Таблет	2
		Компьютер	3
		Смарт телевизор	4
		Бусад	5
9	Интернетэд холбогдох эх үүсвэр	Гар утасны дата	1
		Гэрийн WIFI	2
		Гар утасны дата болон WIFI	3
		Интернет кафе	4
10	Таны ашигладаг гар утасны дугаар хэний нэр дээх бүртгэлтэй вэ ?	Өөрийн нэр дээр	1
		Эцэг эх, гэр бүлийн гишүүний нэр дээр	2
		Хамаатан садны нэр дээр	3
		Найз, нөхдийн нэр дээр	4
		Мэдэхгүй	5
11	Хамгийн их ашигладаг аппликейшныг нэрлэнэ үү (хамгийн чухал 2 хүртэлх хариултыг сонгоно уу )	Фейсбүүк	1
		Инстаграмм	2
		Youtube	3
		Твиттер	4
		Snapchat, wechat	5
		Цахим тоглоом	6
		И-мэйл	7
		Google account	8
Бусад	9		

№	Асуулт	Хариултын кодууд	Алхам
12	Facebook-ийн хэдэн хаягтай вэ?	Нэг	1
		Хоёр	2
		Гурваас дээш	3
13	Та интернэтийг ихэвчлэн ямар агуулгаар хэрэглэдэг вэ?	Найз нөхдийн харилцаа	1
		Мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээж авах	2
		Хэрэгтэй бичлэг, клип, кино хайх	3
		Хичээлтэй холбогдолтойгоор ашиглах	4
		Тоглоом татах, хайх	5
	Бусад	6	
14	Фейсбүүкт ирсэн найзын хүсэлтийг хүлээж авахдаа.....	Таньдаг хүн нэмдэг	1
		Таньдаггүй хүн нэмдэг	2
		Таньдаг болон таньдаггүй хүн нэмдэг	3
15	Та заналхийлсэн, үзэн ядсан, гутаан доромжилсон гүтгэлэг зурвас и-мэйл, фэйсбүүк болон бусад олон нийтийн сулжээний хэрэглэгчдээс авч байсан уу	Тийм	1
		Үгүй	2
			➔ 17
16	Хэрэв тийм бол дараах сонголтуудаас дугуйлна уу?	Гутаан доромжилсон үгтэй сэтгэгдэл	1
		Дарамталсан үг зурвас	2
		Хувийн мэдээллийг нийтэд тараах	3
		Гэмт хэрэгт уруу татагдах	4
17	Интернетэд садар самууныг сурталчилсан, уруу татсан агуулга бүхий мэдээлэлтэй тааралдаж байсан уу ?	Тийм	1
		Үгүй	2
18	Та цахим орчинд танихгүй хүнтэй чаталж байсан уу ?	Тийм	1
		Үгүй	2
19	Үе тэнгийн найз нөхдөө цахим орчинд шоолох, тоглох зэргээр сэтгэгдэл бичих, зураг, дүрс бичлэг оруулж байсан уу ?	Үргэлж	1
		Заримдаа	2
		Огт үгүй	3
20	Та цахим орчинд хувийн нууц, мэдээлэлээ хамгаалах тохиргоог хэрхэн хэрэглэдэг вэ?	Анхан	1
		Дунд	2
		Ахисан	3
		Мэдэхгүй	4
21	Таны эцэг эх интернэт хэрэглээний цаг, агуулга зэрэгт ямар нэг хяналт тавихыг оролдож байсан уу?	Үргэлж	1
		Заримдаа	2
		Огт үгүй	3
22	Таныг хэн нэгэн цахим орчинд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал та үүний эсрэг ямар арга хэмжээ авах вэ?	Найз нөхөдтэйгээ зөвлөлдөнө	1
		Эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандан	2
		Сургуулийн багшид мэдэгдэнэ	3
		Хүүхдийн тусламжийн 108 утасны төвд хандах	4

### АСУУЛТАНД ХАРИУЛСАН ТАНД БАЯРЛАЛАА

## ХАВСРАЛТ 2. АСУУЛГЫН ХУУДАС

### ЭЦЭГ, ЭХЧҮҮДЭЭС АВАХ АСУУЛГА

Таны мэдээллийн нууцыг “ Хувь хүний нууцын тухай” Монгол Улсын хууль болон “Статистикийн тухай” Монгол улсын хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу нууцлан хадгална. Та энэхүү судалгаанд үнэн зөв хариулт өгч оролцсоноор хүүхдийг цахим хүчирхийллээс хамгаалахад шаардлагатай үндсэн мэдээллийг бүрдүүлэх болно.

№	Асуултууд	Хариултын кодууд	
1	Байршил	Хот /аймаг/..... Сум /дүүрэг/.....	Алхам
2	Нас	25-34	1
		35-44	2
		45-54	3
		55-аас дээш	4
3	Хүйс	Эрэгтэй	1
		Эмэгтэй	2
4	Ажил эрхлэлт	Төрийн байгууллага	1
		Хувийн хэвшил, бизнесийн байгууллага	2
		Олон улсын байгууллага	3
		Хувиараа хөдөлмөр эрхлэгч	4
		Тэтгэвэрт	5
		Ажилгүй	6
5	Интернет ашигладаг уу ?	Байнга	1
		Заримдаа	2
		Огт үгүй	3
			→ 8
6	Цахим орчинд хувийн нууц мэдээллээ хамгаалах тохиргооны мэдлэг	Ахисан	1
		Дунд	2
		Анхан	3
		Мэдэхгүй	4
7	Та цахим орчны шүүлтүүрийн программ хангамжийн талаар хэр мэдээлэлтэй вэ?	Шүүлтүүрийн программ ашигладаг	1
		Сонсож байсан	2
		Мэдэхгүй	3
8	Гэрийн интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага хэрэглэгчтэй гэрээ байгуулах үед танай гэр бүлд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг асуусан уу ?	Тийм, асуусан	1
		Үгүй, асуугаагүй	2
		Мэдэхгүй, санахгүй байна	3
9	Хүүхэд тань цахим орчинд үе тэнгийнхний дарамтад өртөж байсан уу ?	Тийм	1
		Үгүй	2
10	Цахим дарамтанд өртөж байснаа гэр бүлийнхэндээ хэлдэг үү ?	Тийм	1
		Үгүй	2
11	Хүүхдийн цахим хэрэглээний эерэг болон сөрөг талуудаас дурьдана уу?	..... ..... .....	

### АСУУЛТАНД ХАРИУЛСАН ТАНД БАЯРЛАЛАА



### ХАВСРАЛТ 3. АСУУЛГЫН ХУУДАС

#### ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ, НИЙГМИЙН АЖИЛТНААС АВАХ АСУУЛГА

Таны мэдээллийн нууцыг “Хувь хүний нууцын тухай” Монгол Улсын хууль болон “Статистикийн тухай” Монгол улсын хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу нууцлан хадгална. Та энэхүү судалгаанд үнэн зөв хариулт өгч оролцсоноор хүүхдийг цахим хүчирхийллээс хамгаалахад шаардлагатай үндсэн мэдээллийг бүрдүүлэх болно.

№	Асуултууд	Хариултын кодууд	Алхам
1	Байршил	Хот /аймаг/..... Сум /дүүрэг/.....	
2	Нас	25-34	1
		35-44	2
		45-54	3
		55-аас дээш	4
3	Хүйс	Эрэгтэй	1
		Эмэгтэй	2
4	Таны ажлын чиг үүрэг	Багш	1
		Нийгмийн ажилтан	2
5	Та интернет ашигладаг уу ?	Байнга	1
		Заримдаа	2
		Огт үгүй	3
			→ 8
6	Цахим орчинд хувийн нууц мэдээллээ хамгаалах тохиргооны мэдлэгээ үнэлнэ үү ?	Анхан түвшинд	1
		Дунд түвшинд	2
		Ахисан түвшинд	3
		Мэдэхгүй	4
7	Та цахим орчны шүүлтүүрийн программ хангамжийн талаар хэр мэдээлэлтэй вэ?	Шүүлтүүрийн программ ашигладаг	1
		Сонсож байсан, ашигладаггүй	2
		Мэдэхгүй	3
8	Цахим орчны зохисгүй хэрэглээний талаар сурагчид мэдээлэл зөвлөгөө авахаар хандаж байсан тохиолдол бий юу?	Байнга	1
		Заримдаа	2
		Огт үгүй	3
9	Танай сургуульд сурагчиддаа зориулсан цахим хэрэглээний аюулгүй байдлын талаар сургалтын модуль, хөтөлбөр бий юу?	Тийм	1
		Үгүй	2
		Мэдэхгүй	3
10	Цахим орчинд хүүхдийн хүчирхийлэл, садар самуун, гэмт хэрэгт уруу татагдсан хүүхдэд зөвлөгөө өгч чадах мэдлэг, туршлагатай гэж өөрийгөө үзэж байна уу?	Тийм	1
		Үгүй	2
11	Хүүхдийн цахим хэрэглээний эерэг болон сөрөг талуудаас дурьдана уу ?	..... ..... ..... .....	

#### АСУУЛТАНД ХАРИУЛСАН ТАНД БАЯРЛАЛАА